



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 2 сарын 17 өдөр

Дугаар СХШ-2024/22

Сүхбаатар сум

Мандал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
Хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 17 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Мандал сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дотоод аудитор, СХШУБ Ц.Уртнасан 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Мандал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал газрын (цаашид сумын Мандал сумын ИТХ гэх)-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Мандал сумын ЗДТГ нь улсын бүртгэлийн 3753735 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130454001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130454401 дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Мандал сумын ИТХ-ын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын хурлын нарийн бичгийн дарга Б.Солонго, 2-р гарын үсгийг ахлах нягтлан бодогч Т.Цэцэгмаа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Сэлэнгэ аймгийн Мандал сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хурлын 2022 оны 51 дүгээр "Бүтэц орон тоо, цалин шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг үндэслэн ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дугаар тушаалаар ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог баталсан байна.

4324001141

Сумын ИТХ нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл болон Нутгийн удирдлага, хууль зүйн бодлогын хороо, Дэд бүтэц хөгжлийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, ХАА, байгаль орчны бодлогын хороо Эдийн засаг төсвийн бодлогын хороо, Өргөдөл гомдлын бодлогын хороо зэрэг 6 бодлогын хороог байгуулж, хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

1.7. Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 6 удаа, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл 6 удаа, багийн иргэдийн Нийтийн Хурал тус бүр 2 удаа хуралдсан байна. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаан, багийн иргэдийн Нийтийн Хуралдаан, сургалт, бодлогын хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт ажлын албаны зүгээс анхаарч ажилласан байна.

1.8. Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд ИТХ-ыг 5 удаа, Нийтийн Хурлыг тус бүр 2 удаа хуралдсан.

Үүнд: Хүснэгт 1.

№	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдсан огноо	Хурлаар	
		Хэлэлцсэн асуудал	Шийдвэрлэлт /тогтоолын дугаар/
1.	2024.01.29	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны үйл ажиллагааны тайлан	125
2.		Сонгуулийн хэсэг байгуулах тухай	126
3.		Шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2024 оны төлөвлөгөөний тухай	127
4.		Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн дээд хэмжээ, төсөл хүлээн авах тов тогтоох тухай	128
5.		Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	129
6.		Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуй нэгжийн 2023 оны гэрээний дүгнэлт	130
7.		2024 оны ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглээ, түлээний мод бэлтгэх хуваарь батлах тухай	131
8.		“Энх мэнд сувилал” ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөө, төсвийн тухай	132

9.		"Тохилог хараа" ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөө, төсвийн тухай	133	
10.		"Мандал шинэ агро техник" ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөө, төсвийн тухай	134	
11.		"Мандал энерго" ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөө, төсвийн тухай	135	
12.	2024.02.29	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	136	
13.	2024.04.25	Санал уламжлах тухай / Сумын сонгуулийн хорооны бүрэлдэхүүн/	137	
14.		Мандал сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хороог батлах тухай	138	
15.		Сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбар, зурагт самбарыг байршуулах байршлыг тогтоох тухай	139	
16.		Мандал сумын ИТХ-ын сонгуулийн тойрог байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, төийг тогтоох тухай	140	
17.		Аялал жуулчлалын маршрут бүс тогтоох тухай	141	
18.		Хаягжуулалтын нэр батлах тухай	142	
19.		"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Мандал суманд хийгдэх арга хэмжээний төлөвлөлтийн тухай	143	
20.		2024.05.30	Сонгуулийн хэсэг байгуулах тухай	144
21.			Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	145
22.	"Мандал энерго" ОНӨААТҮГ-ын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай		146	
23.	"Тохилог хараа" ОНӨААТҮГ-ын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай		147	
24.				

25.		“Энх мэнд” ОНӨААТҮГ-ын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай	148
26.	2024.08.08	Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай	149
27.		Сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас болон зурагт хуудас байршуулах байршлыг тогтоох тухай	150
28.		Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах болон хог хаягдлын үйчилгээний хураамж төвлөрүүлэх журам батлах тухай	151
29.	2024.10.07	Сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай	152
30.		Төсвийн байгууллагын зарим эд хөрөнгийг данснаас хасах тухай	153
31.		Тогтоолын хавсралтанд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /хог хаягдлын тухай/	154
32.		Орон сууц хувьчлах тухай	155
33.		Орон сууц хувьчлах тухай	156
34.		Тогтоолын хавсралтанд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /сонгуулийн хэсгийн байршил өөрчлөх тухай/	157
35.		Санал уламжлах тухай / ОНХС-ын эрэмбэ/	158
36.		Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлттэй зээлийн төслийг сонгон шалгаруулах товыг тогтоох тухай	159
37.		2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх тухай / хоршоонд эзэмшүүлэх газрын байршил /	160
38.		Тэр бум модны хүрээнд мод тарих газар олгох тухай /Иргэн Х.Цэцэгбадам/	161
39.		Мод тарих газар олгох тухай /Иргэн Т.Мэндбаяр/	162
40.		Мод тарих газар олгох тухай /Гэр бүлийн найз бүлэг/	163

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Мандал сумын ИТХ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн

хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2024 оны 3 дугаар улирлын байдлаар 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 242,875.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 242,875.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 198,884.1 мянган төгрөг буюу 81.9 хувийг үйл ажиллагаанд зарцуулж 43,991.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	242,875.2	198,884.1	43,991.1	81.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,875.2	198,884.1	43,991.1	81.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,500.2	198,884.1	40,616.1	83.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	138,018.6	131,723.9	6,294.7	95.4
210101	Үндсэн цалин	44,959.5	58,521.1	-13,561.6	130.2
210102	Нэмэгдэл	41,196.6	42,651.7	-1,455.1	103.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,160.0	2,724.0	-564.0	126.1
210104	Урамшуулал	32,652.9	27,754.0	4,898.9	85.0
210105	Гэрээт ажлын хөлс	17,049.6	73.2	16,976.4	0.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,253.0	16,871.3	381.7	97.8
210201	Тэтгэврийн даатгал	11,731.5	11,594.8	136.7	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	1,314.9	1,265.2	49.8	96.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	853.2	784.7	68.5	92.0
210204	Ажилгүйдлийн даатгал	592.2	594.1	-1.9	100.3
210205	Эрүүл мэндийн даатгал	2,761.2	2,632.5	128.7	95.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
2104	Хангамж, бараа материалын зардал	7,811.5	6,039.5	1,772.0	77.3
210401	Бичиг хэрэг	1,620.0	1,486.3	133.7	91.8
210402	Тээвэр, шатахуун	4,630.5	3,432.6	1,197.9	74.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900.0	731.0	169.0	81.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	661.0	389.6	271.4	58.9
2105	Нормативт зардал				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000.0	3,993.2	10,006.9	28.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,500.0	2,489.9	11,010.1	18.4
210604	Урсгал засвар	500.0	1,503.3	-1,003.3	300.7

2107	Томилолт, зочны зардал	1,125.0	150.0	975.0	13.3
210702	Дотоод албан томилолт	1,125.0	150.0	975.0	13.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,400.0	34,592.9	18,807.1	64.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,400.0	34,592.9	18,807.1	64.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,892.1	5,513.3	2,378.8	69.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	441.0		441.0	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,451.1	5,513.3	1,937.8	74.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,375.0		3,375.0	
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,375.0		3,375.0	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,375.0		3,375.0	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		242,875.2	242,875.2	-
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		242,875.2	242,875.2	-
132001	Орон нутгийн төсвөөс		242,875.2	242,875.2	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		43,991.1	-43,991.1	

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 198,884.1 мянган төгрөг буюу 81.9 хувьтай байгаа нь эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, тээвэр шатахуун, албан томилолтын зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал гэх мэт зардлуудын 3 улирлын гүйцэтгэлээр 43,991.1 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд: Тайлант онд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны даргын 2024 оны А/13 дугаар тушаалаар 14,600.0 мянган төгрөг орлого орж, тус сумын ерөнхий боловсролын 1 болон 4 сургуулийн явган хүний замын тэмдэгтэй лед проектор гэрэл суурилуулсан байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоолт, олголтын байдал

2024 оны эхний хагас жилийн байдлаар сумын ИТХ-ын ажлын албаны цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

2024 онд сумын ИТХ-ын ажлын албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл хийсэн дүн шинжилгээ хийлээ:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	ИТХ	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл

1	Үндсэн цалин	44,959.5	58,521.1
2	Нэмэгдэл	41,196.6	42,651.7
3	Унаа хоолны хөнгөлөлт	2,160.0	2,724.0
4	Урамшуулал	32,652.9	27,754.0
5	Гэрээт ажлын хөлс	17,049.6	73.2
6	Ажил олгогчоос төлөх НДШ	17,253.0	16,871.3
Цалин хөлс НДШ-тэй холбоотой нийт зардлын дүн		155,271.6	148,595.2
Орон тооны мэдээлэл		5	5

Сумын ИТХ нь 3, багийн иргэдийн нийтийн хурал 9, нийт 5 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 155,271.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 148,595.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарын урамшууллыг ажлын гүйцэтгэл тайлангаар нь олгосон байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажууллаа. НДШ-ийн тайлангаар өр, авлагагүй байна.

2.4. Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтөлсөн, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Үндсэн хөрөнгө: 2024 оны эхэнд 96,609.4 мянган төгрөг, 4,179.9 мянган төгрөгийн хөрөнгө /принтер, хяналтын камер/ худалдан авсан ба хасагдсан хөрөнгө байхгүй, 3 дугаар улирлаар нийт 100,789.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр дахин үнэлэх буюу бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ аваагүй 59,722.0 мянган төгрөгийн үнэтэй 14 нэр төрлийн 45 ширхэг хөрөнгө байна.

Бараа материал: 2024 оны эхэнд 21,204.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас төсвийн хөрөнгөөр 39,497.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 25,360.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 16,180.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж 19,161.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.5 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх урсгал болон хөрөнгийн зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн тендер шалгаруулалтын журмыг баримтлан зохион байгуулсан байна.

2.6. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих

Үндсэн хөрөнгө, бараа материалын худалдан авалт, анхан шатны баримтын иж бүрдлийг тулган шалгахад тайлант хугацаанд хийгдсэн худалдан авалт нь хууль, журмын дагуу бүртгэгдсэн байна.

2.7. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын байгууллагаас 2024 онд хийсэн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн акт 104.0 мянган төгрөг, албан шаардлага 24,000.0 мянган төгрөг, зөвлөмж 15,803.7 нийт 37,934.7 мянган төгрөгийн зөрчлийн биелэлт 100 хувьтай байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Мандал сумын ЗДТГ-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, зарцуулалттай холбоотой дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр дахин үнэлэх буюу бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ аваагүй 59,722.0 мянган төгрөгийн үнэтэй 14 нэр төрлийн 45 ширхэг хөрөнгө байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх”, 5.1.5 дах “хэмжигдэхүйц байх”, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийг үндэслэн шийдвэрлэх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Мандал сумын ИТХ-н гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Сэлэнгэ аймаг дахь Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтэст нийт 22,595.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 0413 ангид 1,000.0 мянган төгрөгийн бараа материал, Улаанбаатар төмөр замын өртөөнд 7,500.0 мянган төгрөгийн бараа материал хүлээлгэн өгсөн боловч эдгээр байгууллагууд тухайн хөрөнгийг хүлээн авсан, санхүүгийн бүртгэл тайланд бүртгэсэн эсэх тухай хариу ирүүлээгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй, анхан шатны баримт дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх”, 5.1.5 дэх “хэмжигдэхүйц байх”, 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” 14 дүгээр зүйлийн 14.3.1 “анхан шатны баримт бүрдүүлэх,” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ИТХ-ын ажлын албанаас төсвийн байгууллага, төрийн бус байгууллагад хөрөнгө хүлээлгэн өгөхдөө акт үйлдэх, харилцагч байгууллагаас тухайн хөрөнгийг хүлээн авсан, санхүүгийн бүртгэл тайланд бүртгэсэн эсэх тухай хариу авах, тооцоо нийлсэн акт үйлдэж санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлж байх зөвлөмж хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Мандал сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Мандал сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 90.817.2 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга,

тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдэл нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журамд нийцүүлэн ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД
АУДИТОР САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭСЛЭЭН БАЙЦААГЧ
Ц.УРТНАСАН



ТАНИЛЦСАН:
МАНДАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.СОЛОНГО
НЯГТЛАН БОДОГЧ
Г.ЭЦЭГМАА

